

Level : Ecolier


(Монгол улсын ЕБС-ийн 3 – 4-р анги)

3 онооны бодлогууд:

1) Болор “КЕНГУРУ” гэдэг үгийг будав. Тэр лхагва гаригаас эхлэн өдөр бүр нэг үсэг будсан бол хэзээ энэ үгийг будаж дуусах вэ?


- А) бямба В) ням С) мягмар Д) лхагва Е) пүрэв






2) Агуйн хүн жинлүүр дээр чулуунууд тавьжээ. Жинлүүрийн зүүн тал нь баруун талаас хэдэн килограммаар их байна вэ?



- А) 5 кг В) 7 кг С) 9 кг Д) 11 кг Е) 13 кг

3) Квадратын нэг нүдэнд кенгуру байна. Тэр эхлээд баруун, дараа нь дээшээ, дараа нь зүүн, дараа нь доошоо, хамгийн сүүлд баруун тийшээ тус бүр нэг нүдээр харайсан бол дараах зурагнуудаас аль нь тохирох вэ?




- А)  В)  С)  Д)  Е) 

4) Цолмон цаг хагасын өмнө босжээ. Харин гурван цаг хагасын дараа тэр эмээгийнх рүүгээ явах галт тэргэнд суух ёстой. Тэгвэл Цолмон галт тэрэг хөдлөхөөс хэдэн цагийн өмнө боссон бэ?

- А) 2 цаг В) 3 цаг хагас С) 4 цаг Д) 4 цаг хагас Е) 5 цаг

5) Бүжин дараах таван дүрснээс нэгийг нь сонгосон байна. Уг дүрс нь квадрат биш ба саарал өнгөтэй. Мөн дугуй эсвэл гурвалжин хэлбэртэй гэнэ. Түүний сонгосон дүрс аль нь вэ?



- А) А В) В С) С Д) D Е) E


6) Дэлгүүрээс бамбарууш гурван зайрмаг авахад 1500төгрөг, гавар хоёр зүсэм торт авахад 2400 төгрөг төлжээ. Тэгвэл дудран нэг зайрмаг, нэг зүсэм торт авахдаа хэдэн төгрөг төлсөн бэ?

- А) 1700₮ В) 1900₮ С) 2200₮ Д) 2700₮ Е) 3900₮

7) Цамхагийн цаг нь цагийн тоогоор дуугардаг. Жишээлбэл: 8 цагт – 8 удаа, 9 цагт – 9 удаа, 10 цагт – 10 удаа дуугарна. Мөн хагас цаг болоход нэг удаа дуугардаг бол (8:30, 9:30, 10:30 гэх мэт) 7:55 цагаас 10:45 цагийн хооронд хэдэн удаа дуугарах вэ?

- А) 6 удаа В) 18 удаа С) 27 удаа Д) 30 удаа Е) 33 удаа

8) Хамгийн их талбайтай дүрс аль нь вэ?




4 онооны бодлогууд:

9) Өндгийг 6 ба 12 ширхэгээр нь хайрцаглан савлажээ. Тэгвэл 66 өндгийг савлахад хамгийн багадаа хэдэн ширхэг хайрцаг хэрэгтэй вэ?

- A) 5 B) 6 C) 9 D) 11 E) 13

10) Ангийн сурагчид хамгийн багадаа нэг, хамгийн ихдээ 2 амьтан тэжээдэг. Тэд бүх амьтнаа авчрав (Зураг). Хоёр хүүхэд тус бүр 1 нохой, 1 загастай. Гурван хүүхэд 1 муур, 1 нохойтой бол анги хамгийн ихдээ хэдэн сурагчтай вэ?

- A) 11 B) 12 C) 13 D) 14 E) 15




11) Жаргалын халаасанд 5 ба 10 төгрөгийн нийт 13 ширхэг зоос байв. Аль утга түүний халаасан дахь зооснуудын нийлбэр байх боломжгүй вэ?

- A) 60 B) 70 C) 80 D) 115 E) 125

12) Зурагт үзүүлсэн дүрсийн босоо хар зураасын дагуу нугалахад ямар үсэг саарал өнгөтэй давхцахгүй вэ?

- A) A B) B C) C D) D E) E



13) Алимаа, Бат, Вандан, Гэрлээ, Дэлгэр, Ерөөлт нар шоо орхижээ. Буусан нүднүүд ялгаатай байв.

Алимаад буусан нүд Батынхаас хоёр дахин их

Алимаад буусан нүд Вандангийнхаас гурав дахин их

Гэрлээд буусан нүд Дэлгэрийнхээс дөрөв дахин их


бол Ерөөлтөд буусан нүдний тоог олно уу?

- A) 2 B) 3 C) 4 D) 5 E) 6

14) Тоглоомын дүрэм: Эхлээд оролцогч бүр 10 оноотой байна. Тэд 10 асуултанд хариулах ба зөв хариулбал 1 оноо нэмнэ. Харин буруу хариулбал 1 оноо хасна. Хатагтай Соёлмаа уг тоглоомоор тоглож төгсгөлд 14 оноо авчээ. Тэр хэдэн асуултанд буруу хариулсан бэ?

- A) 7 B) 4 C) 5 D) 3 E) 6

15) Төөрдөг байшингийн квадрат бүрт зүсэм бяслаг байна (Зураг). Бяцхан хулгана энэ байшингаар явж өөрийн чадах чинээгээр бяслаг авахыг хүсчээ. Тэр аль ч квадратыг зөвхөн нэг л удаа дайрч өнгөрөх боломжтой ба хоёр удаа дайрч болохгүй. Тэгвэл хулгана хамгийн ихдээ хичнээн ширхэг (зүсэм) бяслаг цуглууж чадах вэ?




- A) 17 B) 33 C) 37 D) 41 E) 49

16) Үдэслэг дээр ижил хэмжээтэй хоёр бялууг тус бүр дөрвөн тэнцүү хэсэгт хуваав. Дараа нь дахин хэсэг тус бүрийг гурван тэнцүү хэсэг болгов. Ингээд үдэслэгт оролцогч бүр нэг зүсэм бялуу идэхэд гурван зүсэм бялуу үлдэв. Энэ үдэслэгт хэдэн хүн оролцсон бэ?

- A) 24 B) 21 C) 18 D) 27 E) 13


5 онооны бодлогууд:

17) Маша, Саша, Даша, Паша дөрвөн охин урт сандал дээр сууж байв. Эхлээд Маша, Дашатай байраа солив. Дараа нь Даша, Пашатай байр солив. Ингэхэд охид зүүнээсээ баруун луу дараах байрлалаар суусан байв: Маша, Саша, Даша, Паша. Эхлээд тэд зүүнээсээ баруун тийш ямар дарааллаар сууж байсан бэ?





- A) Маша, Саша, Даша, Паша B) Маша, Даша, Паша, Саша
C) Даша, Саша, Паша, Маша D) Саша, Маша, Даша, Паша
E) Паша, Маша, Саша, Даша

18) Дижитал цаг өдөрт хэдэн удаа дөрвөн тоо нь дөрвүүлээ ижил цифртэй байх вэ? Энэ зурагт жишээ болгож хоёр өөр цифрээс бүрдсэн дижитал цагийг үзүүлэв.



- A) 3 B) 24 C) 1 D) 5 E) 12

19) Дөрвөн ижил шоог зурагт үзүүлснээр байрлуулав. Шооны аль ч эсрэг хоёр талсынх нь нийлбэр 7 байна. Тэгвэл зурагт үзүүлсэн дүрс эсрэг талаасаа ямар харагдахыг доорх зурагнуудаас олоорой.









20) Танд зурагт үзүүлсэн гурван өөр карт байна. Эдгээр картаар гурван оронтой тоо хэдийг бүтээж болох вэ? Жишээ нь: 989, 986 гэх мэт.




- A) 4 B) 6 C) 8 D) 9 E) 12

- 21) Цэнгүүн ижил хэлбэртэй жижиг дүрсээр дараах хээг үүсгэжээ. Ингэхдээ жижиг дүрсүүдийн аль ч хоёр нь хоорондоо давхцалгүй байх ёстой. Дараах дүрснүүдээс зурагт үзүүлсэн хээ хийхэд Цэнгүүн аль дүрсээр нь хийж чадахгүй вэ?



- A)  B)  C)  D)  E) 

- 22) Куб хэлбэрийн дүрсүүдийг ашиглан харш барьжээ (Зураг-1). Харшийг дээрээс нь харсан байдлыг зураг-2-т үзүүлсэн байна. Тэгвэл энэ харшийг хэдэн ширхэг куб ашиглан барьсан бэ? Жич: Шал нь кубаар хийгдээгүй.




Зураг - 1

Зураг - 2


- A) 56 B) 60 C) 64 D) 68 E) 72

- 23) Тэнүүн өгсөн дүрсийн дугуй дотор 6, 7, 8 тоонуудыг бичив. Тэр дараа нь 1, 2, 3, 4, 5 тоонуудыг квадратын тал бүрт байгаа тоонуудын нийлбэр 13 байхаар бичив. Тэгвэл будсан дугуйнуудад байх тоонуудын нийлбэр хэдтэй тэнцүү байх вэ?



- A) 12 B) 13 C) 14 D) 15 E) 16

- 24) Сүхээ зургаан өнцөгтүүдийг ашиглан дараах дүрсүүдийг бүтээжээ. Хэрэв тэр энэ дүрсийг үргэлжлүүлэн хийвэл тав дахь дүрс хэдэн ширхэг зургаан өнцөгтөөс бүрдэх вэ?



- A) 37 B) 49 C) 57 D) 61 E) 64